



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 209


Улаанбаатар хот

“Өв ханын материал” ХК-ийн
үнэт цаасны арилжааг сэргээх,
компанийн оноосон нэр өөрчлөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 77 дугаар тогтоолын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Өв ханын материал” ХК-ийн үнэт цаасны арилжааг 2012 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. “Өв ханын материал” ХК-ийн үнэт цаасны арилжааг сэргээхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.
3. “Өв ханын материал” ХК-ийн оноосон нэрийг “Глобал монголиа холдинг” ХК болгон үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/-т, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.
4. Компанийн үйл ажиллагааг сэргээхээр боловсруулсан бизнесийн төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн тайланг 2012 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд ирүүлэх, 2012 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн дотор “ҮЦТТТХТ” ХХК дах данс нь нээгдээгүй байгаа хувьцаа эзэмшигчдийн дансыг компанийн санхүүжилтээр нээлгэхийг “Өв ханын материал” ХК /Пак Чан Сү/-д үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолын 3-т заасан оноосон нэрийн өөрчлөлтийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, энэ тухай Хороонд мэдэгдэхийг “Өв ханын материал” ХК /Пак Чан Сү/-д тус тус үүрэг болгосугай.
6. Үнэт цаасны арилжааг сэргээж байгаатай холбогдуулан цаашид үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тогтоомж болон “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа чанд баримтлаж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ажиллахыг “Өв ханын материал” ХК /Пак Чан Сү/-д даалгасугай.
7. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН